Ённам их сургуулийн солонгос хэлний сургалтын төвийн Үйл ажиллагааны удирдамжийн танилцуулга

1. дүн

- дундын шалгалт(40%)+эцсийн шалгалт(40%)+сорил(20%) гэсэн байдлаар Үнэлэгдэнэ.

дундын шалгалт		эцсийн шалгалт		нийт
сонсох, бичих унших, ярих	сорил 1, 2	сонсох, бичих унших, ярих	сорил 3, 4	
40%	10%	40%	10%	100%

① Ирц 80%-с дээш байх ба дундаж дүн 70%-с дээш тохиолдолд дараагийн түвшинд шилжин суралцах боломжтой.
② Ирц 80%-с бага эсвэл дундаж дүн 70%-с бага бол тухайн түвшиндөө дахин суралцах шаардлагатай болно.

2. Ирц
(1) Хичээл тогтсон цагт эхлэх бөгөөд хоцролт болон хичээл таслалт хатуу хянагдана.
(2) Нийт хичээлийн цагийн 80%-д ирцтэй байх шаардлагатай.
(3) 3 удаа хоцорсон эсвэл эрт явсан тохиолдолд тус бүр 1 цагийн хичээл таслалт гэж тооцно.
(4) Дараах тохиолдлуудад нотлох баримт бичиг өгсөн тохиолдолд ирцэнд бүртгэнэ.
① Өөрөө эмнэлэгт үзүүлсэн эсвэл хэвтэн эмчлүүлсэн бол (жор эсвэл эмчийн дүгнэлт, амбулаторийн эмчилгээг 5 хүртэл хоногт хүлээн зөвшөөрнө)
② Хууль ёсны халдварт өвчин батлагдсан тохиолдолд (эмнэлгийн байгууллагын батламж эсвэл эмчийн дүгнэлт)
③ Өөрийн болон шууд төрөл садны баяр ёслолд оролцсон тохиолдолд (7 хүртэлх хоногт хүлээн зөвшөөрнө)
④ Өөрөө төрсөн тохиолдолд (20 хүртэл хоногт хүлээн зөвшөөрнө)
※ Ирцийн цаг тооцогдсон тохиолдолд тасалсан ирцтэй сурагчдын ангиллаас хасагдана.

3.Оюутны удирдамж

(1) Оюутны зөвлөгөө

① Оюутан сургалтын явцад болон төгссөний дараа цаашид суралцах, эх орондоо буцах, ажилд орох зэрэг төлөвлөгөөгөө сургалтын төвд мэдэгдэх шаардлагатай.

② Оюутан цагийн ажил хийхийг хҮсвэл сургалтын төвөөс зөвшөөрлийн бичиг авах ёстой.

③ Өвчин, байгалийн гамшиг зэрэг зайлшгҮй шалтгаанаар урьдчилан зөвшөөрөл авсан тохиолдлоос бусад тохиолдолд хичээл таслалтын тоо хэтэрсэн тохиолдолд анги удирдсан багш болон захиргааны албаны зөвлөгөөнд оролцох ёстой.

(2) Сахилгын арга хэмжээ болон сургалтаас хасах

① Дараах тохиолдлуудад Үйл ажиллагааны зөвлөлийн хэлэлцҮҮлгээр сахилгын арга хэмжээ авч болно.

ㄱ. Хичээлийн хэвийн явцыг болон суралцах орчныг алдагдуулах Үйлдлийг давтан гаргасан тохиолдолд

ㄴ. Бэлгийн дарамт, бэлгийн хҮчирхийлэл, хҮний эрхийг зөрчсөн Үйлдлийг гаргасан тохиолдолд

ㄷ. Хэвийн сургалтын ажлыг саатуулах эсвэл тасалдуулах Үйлдлийг гаргасан тохиолдолд

② Дараах тохиолдлуудад сургалтаас хасаж болно.

ㄱ. Сургуулийн нэр хҮндийг гутаасан ноцтой алдаа гаргасан тохиолдолд

ㄴ. Тухайн тҮвшинд 3 удаа улирсан тохиолдолд

ㄷ. Хичээл таслалтын цаг 60-аас давсан тохиолдолд

ㄹ. Бусад суралцах боломжгҮй тохиолдолд